

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

12/19/2023

Өлгий сум

ЗДҮАХ-Т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)				Хэрэгжилт	Хувь
							2022он		2023 он			
							Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв /саяаар/	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв		
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО. ЭРДЭМ БОЛОВСРОЛД ЭРС ӨӨРЧЛӨЛТ												
Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг бүрдүүлнэ.	1	"Эко сургууль" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021-2024	Орон нутгийн төсөв	4.0	Хөтөлбөрийн хэрэгжилт 30%	Хөтөлбөрийн хэрэгжилтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна. /Биелэлт 40 хувьд хүрсэн байна/	1.0	Хөтөлбөрийн хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулиудын эко клубуудын багш, сурагчдын төлөөлөлүүдэд байгаль орчныг хамгаалах дадал хэвшлийг бий болгох, эх дэлхийгээ хайрлан хамгаалахад сургах зорилгоор Боловсрол шинжлэх ухааны газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын төвтэй хамтарч "Ногоон хөгжил", "Мэргэжил сонголтын ач холбогдол", "Эко сургууль болох 7 алхам", "Хөрсний бохирдол" сэдвүүдээр сургалт зохион байгуулав. Үг сургалтад оролцсон 3 багш, 21 Эко клубийн сурагчидтай санал солилцож, 2023 онд хийх ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ажиллаа.	90	
ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ, УЛАМЖЛАЛТ СОЁЛ												
Түүх, уламжлал, өв соёл, зан заншил, соёл, урлагийн бүтээлийг хөгжүүлэн, тогтвортой хөгжлийг хангаж, сурталчилна.	2	Бүргэдийн баярт гадаад орнуудын бүргэдчдийг оролцуулан олон улсын хэмжээнд сурталчилна.	2021-2024	ОНТөсөв	20.0	Өндөр түвшинд зохион байгуулагдсан байна.	Өндөр түвшинд зохион байгуулагдсан байна.	5.0	Өндөр түвшинд зохион байгуулагдсан байна.	"Бүргэдийн баяр-2023" эвент арга хэмжээ 24 дахь удаагаа 2023 оны 9 сарын 30, 10-р сарын 01- өдөр Баян-Өлгий аймгийн Буянт сумын 3-р багийн Шар нуурын "Хойлог" толгой хэмээх газарт батлагдсан хөтөлбөр ёсоор амжилттай зохион байгуулагдав. Тус арга хэмжээнд аймгийн Музей,МАНХСЭХЗахиргаа, ЗАСХТ зэрэг газрууд өөрсдийн бодлого гадаад, дотоод аялагчидад үзэсгэлэн байршуулан онцлогоо казах гэр барьж сурталчлан ажиллав. Энэ жилийн "Бүргэдийн баяр"-ийн арга хэмжээнд 13 сумаас 160 гаруй бүргэдчид, гадаадын жуулчин 800, нийт 5000 гаруй үзэгчид оролцов. УБ хотод 2023 оны 03-р сарын 04,05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бүргэдийн баярт, тус аймгаас 11 бүргэдчдийг оролцуулав.	90	
АШИГТ МАЛТМАЛ, АРД ТҮМНИЙ САН ХӨМРӨГ												
Уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.	6	Хариуцлагатай уул уурхайг дэмжиж, уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад хуулийн хүрээнд дэмжиж ажиллана.	2021-2024			Ашиглалтад орсон үйлдвэр байхгүй.	Хуулийн хүрээнд дэмжсэн байна.		Хуулийн хүрээнд дэмжсэн байна.	Цэнгэл сумын алтаны уурхайн "ЭС ЖИ ГРУПП" ХХКомпани үйл ажиллагааг холбогдох хуулийн хүрээнд дэмжин ажиллаж байна.	90	
	7	Аймгийн хэмжээнд уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг хуулийн хүрээнд бодлогоор дэмжиж, хяналт тавьж, хамтран ажиллана.	2021-2024				Хяналт, шалгалт хийсэн байна		Хяналт, шалгалт хийсэн байна	2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон БОАЖЯ-ийн Салбарын улсын Ерөнхий байцаагчийн баталсан 01/14 тоот "Байгаль орчны хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт хийх тухай", 01/10 тоот "Авто замын өргөтгөл, шинээр барих, геологи, уул уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийсэн байдалд урьдчилан сэргийлэх шалгалт, судалгаа хийх тухай" удирдамжуудын дагуу аймгийн БОАЖГ зарын байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагчид Цэнгэл сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Эс жи групп" ХХК-ийн "Цагаан овоот уул" алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах уурхайн үйл ажиллагаанд 2023 оны 09-р сарын 01-ний өдөр 01.1.4 кодтой "Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас"-аар төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, эрсдэлийг үнэлж ажилласан ба илэрсэн зөрчилтэй холбогдуулан улсын байцаагчийн хамтарсан 9 заалт бүхий 1 албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Ногооннуур сумын 3-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаад түр зогссон "ЮУШИЭНГМИНГ"ХХК-ийн эзэмшилд байгаа Дулаан хар уурхайд хадгалагдаж байгаа 30-40 орчим тонн Цайрын сульфат, содын хадгалалт, хамгаалалтын байр нь стандартын шаардлага хангахгүй ил задгай агуулахад хадгалсан зарчлийг илрүүлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, Зөрчлийн тухай хуулийн 5.11-р зүйлийн 1.1.6-д заасны дагуу торгуулийн арга хэмжээ авч зөрчил арилгуулах хугацаат эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч зөрчлийг ойрын хугацаанд арилгуулах даалгавар өгч ажиллав.	100	
	8	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжүүдийг хуулийн хүрээнд бодлогоор дэмжиж, хяналт тавина.	2021-2024				Хяналт, шалгалт хийгдсэн байна		Хяналт, шалгалт хийгдсэн байна	"Жол"ХХК-ны Толбо суманд баригдсан 2.3 км хатуу хучилттай авто замд ашигласан 2 га хайрагны талбай болон Бугат сумын Хатуу багийн нутагт баригдсан ветон гүүрэнд ашигласан 2 га хайрагны харерийн талбайг нөхөн сэргээж орон нутагт актаар хүлээлгэж өгөв.	90	

Уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээх арга хэмжээ авна.	9	Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийлгэнэ.	2021-2024	хувийн хэвшил, ААН		2.2 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.	Эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.		Эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.		"Эс жи групп" ХХК нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу далд аргаар эвдрэлд орсон газрыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр 4.2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж ажилласан байна. Сасгай сумын нутаг дэвсгэрт "Орд талс ресурс" ХХК нь "Бөхийн хөндий" гэх газарт нийт 5 цооног, 370 тууш метр өрөмдөж, 150 урт метр канал ухаж хайгуулын ажил хийж, эвдрэлд орсон 2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн байна.	70
АЛТАЙН ХИШИГ - АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ												
Аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.	10	Аймгийг аялал жуулчлалын бүс болгох боломжийг бүрдүүлнэ.	2021-2024			0	Бүс тогтоох судалгаа хийгдсэн байна.		Бүс болгох асуудлыг шийдвэрлүүлсэн байна.		аймгийн ЗДТГазраас тус аймгийн Байгаль, Түүх, Соёлын онцлогийг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан, Засагийн газарт өргөн мэдүүлээд байна.	50
	11	Өвлийн болон адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.	2022-2024	Хувийн хэвшил, төсөл хөтөлбөр		Аялал жуулчлалын нэг төрлийн бүтээгдэхүүн байна.			Эвент арга хэмжээний тоо 2-оор нэмэгдсэн байна.		Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх эвент арга хэмжээний жагсаалтыг аймгийн ЗДаргад хүргүүлж, сум бүр зохион байгуулах эвент арга хэмжээний нэр төрлийг гаргаж ИТХуралд оруулахаар хүргүүлсэн.	70
	12	Аялал жуулчлалын салбарыг сурталчлах, таниулах аялалын маршрут, шторк, гарын авлага материал боловсруулж, хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	2021-2022	ОНТөсөв, хувийн хэвшил, төсөл хөтөлбөр	6.0			Гарын авлага материал хэвлүүлсэн байна.	4.0	Гарын авлага материал хэвлүүлсэн байна.		Герман улсын хамтын ажиллагааны GIZ төсөлд хүсэлт 500 ширхэг "Аялал жуулчлалын танилцуулга" номыг хэвлүүлээд байна.
Аялал жуулчлалын газрын дэд бүтцийг шийдвэрлэн жуулчдын аялах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	13	Алтай таван богд уулын тусгай хамгаалалттай газрын Тахилгын овоо хүртэлх замыг сайжруулан засаж, ашиглалтад оруулна.	2023-2024	Улсын төсөв, төсөл хөтөлбөр							Хэрэгжээгүй байна.	30
	14	Эко аялал жуулчлалын орчныг бүрдүүлэх, аялал жуулчлалын нэр бүхий газруудад отоглох, хоноглох цэг байгуулж, хяналтыг сайжруулна.	2021-2024	ОНТөсөв, хувийн хэвшил, төсөл хөтөлбөр			Эко орчин бүрдсэн байна. /2 цэг байгуулна/		Эко орчин бүрдсэн байна. /3 цэг байгуулна/		Цэнгэл сумын Хотон, Хурган нуурын нарийн гүүрийн дэргэд Отоглох хоноглох цэг барих ажлыг "Ранго трейл ХХК" гэрээгээр авч, гүйцэтгэв.	100
	15	Аялал жуулчлалын бүс нутгийг аялагчдад таниулах тэмдэг, тэмдэглэгээг тавина.	2021-2024	ОНТөсөв, хувийн хэвшил	8.0		Аялагчдад таниулах тэмдэг, тэмдэглэгээ хийгдсэн байна	2.0	Аялагчдад таниулах тэмдэг, тэмдэглэгээ хийгдсэн байна		Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас WELCOME TO MONGOLIA самбарыг аймаг бүрт орох гарах төв зам дагуу болон угтах, үдэх хаалганы орчимд самбарт байрлуулах талаар өгсөн үүрэг даалгаврыг дагуу Аялал жуулчлалын хөгжлийн төвийн 510,000 төгрөгийн санхүүжилтээр сурталчилгааны самбарыг замын 2 талд байршуулав. Тус аймгийн аялал жуулчлалын бүс нутгуудад замын тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбар байршуулах нэр бүхий 10 газрыг сонгон авч шаардагдах тооцооллыг аймгийн ЗДаргад хүргүүлээд байна.	90
ТӨР, ТҮМНИЙ ЭРГЭХ ХОЛБОО												
Иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай хүргэнэ.	16	Төрийн байгууллагуудын цахим хуудсыг шинэчлэх, ашиглалтыг сайжруулан мэдээллийн ил тод байдлыг хангана.	2021-2024	ОНТөсөв	20.0		Программ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлнэ	5.0	Программыг бүрэн нэвтрүүлсэн байна.		Байгууллагын /http://nature.bo.gov.mn/ хаягтай хуучин веб сайтыг шинэчилж, орчин үеийн ухаалаг хэрэглээнд тохируулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 заалт, Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 1/2673 дугаар зөвлөмжийн дагуу 150 гаруй мэдээлэл, өдөр тутмын үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байна.	100
	17	Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, санал, гомдлын үйл ажиллагааг цахимжуулах, шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд нь хэрэгжүүлнэ.	2021-2024	Улсын төсөв			Иргэдийн өргөдөл, гомдлыг 80% цахимжуулна. Хуулийн хугацаанд 80% шийдвэрлэнэ.		Иргэдийн өргөдөл, гомдлыг 81% цахимжуулна. Хуулийн хугацаанд 81% шийдвэрлэнэ.		Иргэдийн өргөдөл, санал, гомдлын үйл ажиллагааг байгууллагын Веб сайтаар дамжуулан цахимаар хүлээж авах системийг нэвтрүүлэн, 2023 оны э байдлаар 168 иргэнээс ирүүлсэн шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд нь хэрэгжүүлж ажиллав.	100
	18	Төрийн бодлого, шийдвэрийг тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хэлбэрээр тогтмол мэдээлж, сурталчилна.	2021-2024	ОНТөсөв	4.0		Иргэд цаг үеийн мэдээ, мэдээллээр тогтмол хангагдсан байна.	1.0	Иргэд цаг үеийн мэдээ, мэдээллээр тогтмол хангагдсан байна.		Хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн хэвэл мэдээлэл, орон нутгийн олон нийтийн радио, байгууллагын веб сайт, цахим хуудас ашиглан Байгаль орчны багц хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээрийн хүрээнд гарсан тогтоол шийдвэрийн талаар тухай бүр тогтмол сурталчлан ажиллаж байна.	100

	19	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	2021-2024				Төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдсан байна.	Төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдсан байна.	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын Баян-Өлгий аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран байгууллагын ERP программыг дотоод хэрэгцээндээ нэвтрүүлэн, бүрэн ашиглах сургалтад байгууллагын холбогдох албан хаагч нарт цахимаар хамруулав. Байгууллагын нийт албан хаагчдад "Төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах" ажлын хүрээнд, цахим ур чадварын мэдлэг олгох сургалтыг зохион байгуулав.	100	
Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэн ажлын уялдаа холбоог сайжруулж, дотоод мэдээлэл	20	Үндэсний цахим үйлчилгээ "E-Mongolia" программыг аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлж, захиргааны байгууллагаас олгодог зөвшөөрөл, тодорхойлолтыг бүрэн цахимжуулна.	2021-2024	ОНТөсөв	80.0	Able системтэй байгууллага 4	Дотоод мэдээлэл солилцооны програмтай болсон байна.	Дотоод мэдээлэл солилцооны програмтай болсон байна.	E-Mongolia цахим порталын талаар: Аймгийн хэмжээнд 37 үйлчилгээ оруулсан ба тус байгууллагаас дараах 3 үйлчилгээг нэвтрүүлж, иргэн ААНэгж байгууллагуудаас цахимаар үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. 1. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ 2. Ус ашиглах зөвшөөрөл олгох 3. Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлт хүлээн авах	100	
ТАВ. ЭРҮҮЛ, ЦЭВЭР, АЮУЛГҮЙ ОРЧИН ЭЭЛТЭЙ ЭКО БҮС											
Орчны бохирдол, хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.	32	Аймаг болон сумын төвүүдийн бүх байгууллага, ААН-ийг стандартын шаардлага хангасан нэг загварын ангилан ялгах хогийн савтай болгох арга хэмжээ авна.	2021-2024	Улсын төсөв, төсөл хөтөлбөр			Стандартын шаардлага хангасан хогийн савтай болсон байна	Стандартын шаардлага хангасан хогийн савтай болсон байна	1. Аймгийн төвийн аж ахуйн нэгж байгууллагуудын дунд хог хаягдлын тухай хуулийг сурталчлах, байгаль орчноо цэвэрлэх, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, ангилан ялгах хогийн савтай болгох, ангилан ялгах хэвшүүлэх зорилгоор "ХОЛИВОЛ ХОГ, АНГИЛБАЛ БАЯЛАГ" уралдаан зохион байгуулсан. Уг уралдаанд 8 аж ахуйн нэгж, байгууллагууд идэвхтэй оролцож өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан ба бүх оролцогчид ангилан ялгах хогийн сав хийлгэж хогийг ангилан ялгах хаях арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна. 2. Мөн аймгийн төвийн төв талбайд орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2 том оврын ангилан ялгах хогийн сав хийлгэж байршуулсан. 3. Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2. заалтыг хэрэгжилтийг хангуулах зорилгоор сумын болон аймгийн төвийн аж ахуйн нэгж, байгууллагуудад стандарт шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав хийлгэх шардлага тавьж албан бичиг хүргүүлж ажилласнаар нийтдээ 12 аж ахуйн нэгж байгууллагууд ангилан ялгах хогийн савтай болсон.	90	
	33	Ахуйн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулна.	2021-2024	Улс, ОНТ, төсөл хөтөлбөр			Газрын асуудал шийдвэрлэгдсэн байна.	Үйлдвэртэй болсон байна.	1. Аймгийн төвд хог хаягдлыг дахин боловсруулах төсөл бичиж Азин хөгжлийн банк, Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтэд даасан зохицох, КФВ олон улсын төсөлд төсөл бичиж хүргүүлсэн боловч дэмжигдсэнгүй. Харин аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг "КАЗОС" ХХКомпани 2 сарын хугацаанд 30 тонн гаруй хуванцар хаягдлаа цуглуулсан байна. 2. Хуванцар хаягдлын нэг кг-ийг 150 төгрөгөөр ард иргэдээс худалдаж авдаг юм. Хуванцар болон гялгар уутыг механик аргаар пресслэх машиныг 300 мянган төгрөг зарцуулан өөрөө хийсэн ба цуглуулсан хуванцарыг Узбекистан Улс болон Улаанбаатар хотод хүргүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. 3. Аймгийн төвийн аж ахуйн нэгж байгууллагуудын дунд хог хаягдлын тухай хуулийг сурталчлах, байгаль орчноо цэвэрлэх, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, ангилан ялгах хогийн савтай болгох, ангилан ялгах хэвшүүлэх, дахивар цуглуулах зорилгоор "ХОЛИВОЛ ХОГ, АНГИЛБАЛ БАЯЛАГ" уралдааны зохион байгуулсан. Уг уралдааны хүрээнд 15 ортер дахин боловсруулах хог хаягдал цуглагдсан байна.	90	
Өлгий сумын агаарын бохирдлыг бууруулж, агаарын чанарын хяналтыг сайжруулж "Утаагүй Өлгий" болох бодлого хэрэгжүүлнэ.	34	Өлгий сумын агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, түүнд мөрдөх журмыг баталж, хэрэгжүүлнэ.	2021-2024				Журам батлагдсан байна.	Журмыг мөрдөж, хэрэгжилтийг хангуулсан байна.	Өлгий сумын төвийн "Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журам батлах тухай" А/447/А/818 дугаар хамтарсан тушаал, захирамжийг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6036 дугаарт бүртгүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	90	
	35	Айл, өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшийг түгээх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.	2021-2024	Улсын төсөв			Сайжруулсан түлш үйлдвэрлэх судалгааны ажил хийгдсэн байна.	Хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн байна.	хэрэгжээгүй байна.	30	

	37	Усны нөөцийг бохирдох, хомсдохоос сэргийлж, усны сан бүхий газрыг хамгаалтад авна.	2021-2024					Хамгаалалтад авсан байна	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоолох зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран 12 сумын бүх шатны албан тушаалтан, нутгийн иргэдэд сургалт, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, 2000 ширхэг гарын авлага тарааж ажилласан. Булаг шандын эхийг хамгаалж, орчныг тохижуулах, нээлттэй сонгон шалгаруулалт явагдаад Алтай, Бугат сумдын нутаг дэвсгэрт орших 2 булгийн эхийг хамгаалах ажил энэ оны 4 дүгээр улиралд хийгдэхээр төлөвлөж байна. Хамгаалалтын бүсийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн ИТХ-аар оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	90	
Ойн нөөц, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна..	38	Эко ногоон аймаг болгох зорилт дэвшүүлж, аймгийн хэмжээнд мод тарих ажлыг өргөжүүлэн шинээр ногоон байгууламжийн бүс байгуулна.	2021-2024	ОНТөсөв		107	Ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байна.	Ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байна.	Аймгийн Засаг даргын 2023 оны А/181 дугаартай захирамжаар баталсан "Аймгийн хэмжээнд таван зуун мянган ширхэг мод тарьж ургуулах аян"-ыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 06-р сарын хугацаатай зохион байгуулахаар төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хаврын модны үзэсгэлэн худалдааг аймгийн төв талбайд зохион байгууллаа. Үзэсгэлэнд аймгийн Сум дундын ойн анги болон "Ногоон Өлгийн Ой" ХХК, "Балгын" ХХК зэрэг аж ахуй нэгжүүд оролцон Улиас, Бургас, Хайлаас, Шар хуайс, Алим, Чавга, Үхрийн нүд, Чацаргана, Монос зэрэг 10 төрлийн тарьц суулгацыг худалдаалж иргэдэд тарих, арчлах зөвлөмж өглөө. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Ногоон Өлгий дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны 04-р сарын 21-ний өдрийн А/184 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. 2023 оны хавар, намрын мод тарих үеэр аймгийн хэмжээнд нийт 63012 ширхэг 10 гаруй төрлийн мод, бут сөөг таригдсан ба нийт 183 аж ахуй нэгж, байгууллага, 5996 иргэн оролцов.	90	
	39	Байгалийн баялаг нөөц хамгаалах нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг чадавжуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	2021-2024	ОНТөсөв	4.0	Нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа сайжирсан байна.	Сургалтад хамрагдсан байна	1.0	Сургалтад хамрагдсан байна	Цэнгэл суманд 2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн санхүүжилтээр 10.0сая төгрөг батлав. Сагсай суманд 2023 онд Байгаль хамгаалах нөхөрлөлүүдэд зургийн аппарат, телескоп зэрэг тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор 8.0сая төгрөгийг энэ оны 4-р улиралд зарцуулахаар сумын ИТХ-ын 2022 оны 12-р сарын 22-ны өдрийн 2023 оны төсөв батлах тухай 53 дугаар тогтоолын хавсралтаар батлав. Алтай суманд 2023 оны ан амьтан ашигласны төлбөрийн орлогоос ангийн нөхөрлөлүүдийг дэмжих зорилгоор 10 сая төгрөг арцуулахаар төлөвлөн ажиллаж байна. Аймгийн хэмжээний агнуурын бүс нутгийг хариуцагч менежментийн компаниуд нөхөрлөлүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж байна.	90
	40	Аймгийн хэмжээний ан, агнуурын менежментийн төлөвлөгөөг батлуулна.	2023	ОНТөсөв	50.0	Аймгийн агнуур зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хугацаа дууссан.			төндөрт шалгарсан "Агнуур судлалын нийгэмлэг" ТББайгууллагатай гэрээ байгуулж гэрээний дагуу аймгийн хэмжээний ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хийлгэж, аймгийн ИТХурлын ээлжит арван долдугаар хуралдаанд оруулан хэлэлцүүлж 195 дугаар тогтоолоор батлуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэв.	100	

Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.	41	Байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг хууль хяналтын байгууллага, хамтрагч талуудын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.	2021-2024			Хууль бус ашиглалт 40 хувиар буурсан байна.	Хууль бус ашиглалт 50 хувиар буурсан байна.		Жилд нэг удаа	<p>Аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Зооноз өвчин судлалын төв, Өлгий сумын ЗДТГ газартай хамтарч нэгдсэн хяналт шалгалт хийж, хууль бусаар ан амьтан агнасан, байгалийн жамаар унасан зэврийг түүж бэлтгэсэн нийт 2 иргэнд 6,600,000 төгрөгийн торгууль, 104,676,000 төгрөгийн нөхөн төлбөр тавьж, ховор амьтны жагсаалтанд орсон 1 тооны Зэгсний гахай агнасан 1 иргэн, 162 ширхэг эсгий гэрийн мод бэлтгэсэн зөрчлийг илрүүлэн Цагдаагийн газарт шилжүүлэх, Хяналт шалгалтын явцад хураагдсан 12 ш загасыг устгаж, 3 ширхэг загасын тор, 182 ширхэг халиун буын эвэр, 13 тооны галт зэвсэг, 1 тооны халиун буга зэргийг улсын орлого болгуулахаар Өлгий сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд болон аймгийн Цагдаагийн газарт хүргүүлэн шийдвэр гаргуулж ажиллалаа. Мөн хууль бусаар олсон 14,000,000 /арван дөрвөн сая төгрөг/ төгрөгийг улсын орлого болгуулахаар аймгийн Санхүү төрийн сангийн дансанд тушаалгахаар шийдвэрлэж шилжүүлэв.</p> <p>- Барагшун тээвэрлэсэн зөрчлийг илрүүлж, иргэн С.Е-д 150.000 төгрөгийн торгууль ногдуулж, зөвшөөрөлгүй тээвэрлэсэн 397 кг барагшуныг хурааж, сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд устгуулахаар шилжүүлэн шийдвэр гаргуулж ажилласан.</p> <p>Өлгий сумын 4 дүгээр багт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн Б-гийн биологийн идэвхт бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд /барагшун боловсруулах үйлдвэрт/ хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн дагуу иргэн Б-д 300.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан барагдуулж, зөрчлийн үр дагаврыг арилгуулах арга хэмжээ авч ажиллав.</p> <p>Хог хаягдлын хяналтын чиглэлээр:</p> <p>Өлгий, Бугат сумын төвийн нутаг дэвсгэрт орших Ховд голын хамгаалалтын бус, Баяннуур сумын төв гудамж талбай, нийтийн эдэлбэр газарт ил задгай хаясан хог хаягдлыг тухайн сумуудын удирдлагуудад танилцуулж, холбогдох хууль, журам, стандартын дагуу арга хэмжээ авч арилгуулах талаар байцаагч, байгаль хамгаалагч нарт үүрэг чиглэл өгч, зөрчлийг бүрэн арилгуулж ажиллав.</p> <p>Хог хаягдлыг зориулалтын бус газарт хаясан 2 зөрчил, ил задгай хог хаягдлыг шатаасан 1 иргэн, 2 ААНэгж, Бугат сумын нутаг дэвсгэрт орших Ховд голын эргээс хууль бусаар хайрга олборлож тээвэрлэсэн 2 зөрчил илрүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллав.</p>	100
	42	Хавар, намрын хуурайшилт ихтэй үед ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх сурталчилгааг мэдээллийн бүхий л хэрэгслээр ард иргэдэд хүргэнэ.	2021-2024			СДОАнги, БОАЖГ, сумдын ЗДТГ,	Ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлнэ		Ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлнэ	Ой хээрийн түймэрийн улмаас экологийн тэнцвэр алдагдах ойн санд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гарсан "Бугын эвэр түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглох тухай" БОАЖСайдын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/70 дугаар тушаал болон аялал зугаалгын үеэд ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх сэрэмжүүлэгийг байгууллагын Веб сайт, Фейсбук хуудасаар, орон нутгийн хэвэл мэдээллээр хавар намрын үеэд тогтмол ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулж байна.	90
СУМ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО											
ТӨРӨЛХ НУТАГ, ТӨГӨЛДӨР ХӨГЖИЛ											
Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх, төвлөрсөн цэгт булаах, хог хаягдлын хэмжээг бууруулж, хөрсний бохирдлыг бууруулах, Өлгий сумын гэрэлтүүлэг, камержуулалт зэрэг дэд бүтцийн тохижилтын ажлыг сайжруулна.	43	Өлгий сумд хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, дэд бүтцийн тохижилтын ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.	2021-2023				Газрын асуудлыг шийдвэрлүүлсэн байна.		Шинэ хогийн цэгтэй болсон байна.	<p>1. Аймгийн нэгдсэн хогийн цэг салхины зонхилох чиг, Уерийн ус урсах бус, суурьшлын бус буюу айл өрхөд ойрхон, хүн ам, байгаль орчинд аюул, эрсдэл учруулж байсан тул Бугат сумын Хүрэнгийн хяр хэмээх газарт нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэж байна.</p> <p>2. Хуучин Цагааннуур тосгоны удаан жил хуримтлагдсан аялал жуулчлалын бүст байршилтай хогийн цэгийг БОАЖЯам болон орон нутгийн төсөв хөрөнгөөр цэвэрлэж, нөхөн сэргээлтийн ажил хийгдэж байна.</p>	70
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ										87.0	

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР